



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 1 дүгээр  
сарын 31-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар  
хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

1. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газартай хамтран 2018 онд Улаанбаатар хотод зохион байгуулах Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын 2 дугаар бага хурлын бэлтгэлийг хангах ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- |         |   |
|---------|---|
| Дарга   | -Монгол Улсын Шадар сайд  |
| Гишүүд: | -Гадаад харилцааны сайд;<br>-Нийслэлийн Засаг дарга;<br>-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;<br>-Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;<br>-Батлан хамгаалахын дэд сайд;<br>-Сангийн дэд сайд;<br>-Зам, тээврийн хөгжлийн дэд сайд;<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд;<br>-Барилга, хот байгуулалтын дэд сайд;<br>-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд;<br>-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;<br>-Эрүүл мэндийн дэд сайд;<br>-Онцгой байдлын ерөнхий газрын дарга;<br>-Монгол Улсын Шадар сайдын онцгой байдлын асуудал хариуцсан зөвлөх; |

-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны ахлах референт (зөвшилцсөнөөр);

-Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал.

Нарийн бичгийн дарга:

-Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;

-Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал.

2. Бага хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг нь ханган ажиллаж, бэлтгэл ажлын хүрээнд тодорхой асуудал хариуцсан холбогдох яам, агентлаг, байгууллагын төлөөлөл бүхий дэд ажлын хэсэг байгуулахыг Ажлын хэсэг (У.Хүрэлсүх)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ